



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

Жагсаалт батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалт, сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хэсгийн 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Удаан хугацааны туршид хэрэглэх шаардлагатай, тодорхой худалдааны нэршил бүхий эмийг тогтмол, тасралтгүй борлуулах хүчин чадал бүхий эмийн сангийн сонгон шалгаруулалтад тэнцсэн эмийн сангийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад заагдсан эмийн сантай даатгалын гэрээ байгуулах ажлыг 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн дотор зохион байгуулахыг Тамгын газар /Г.Бат-Эрдэнэ/-т, шаардлагатай эмийн төсвийг хуваарилж, хэрэгжилтийг зохион байгуулахыг Бодлогын хэрэгжилтийн газар /Г.Гийхнаран/-т, холбогдох програм хангамжид нэмэлт, өөрчлөлт оруулахыг Мэдээллийн технологийн хэлтэс /Х.Бат-Оргил/-т, батлагдсан төсвийн хүрээнд тусламж, үйлчилгээний зардлыг гүйцэтгэлээр тооцож, санхүүжилтийг олгохыг Санхүү, төлбөрийн хэлтэс /Б.Болормаа/-т тус тус үүрэг болгосугай.

3. Сонгон шалгаруулалтад тэнцсэн эмийн сангуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх, Эрүүл мэндийн даатгалын байгууллагын цахим хуудсанд байршуулахыг Олон нийттэй харилцах хэлтэс /Б.Энхтуяа/-т даалгасугай.


4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /Б.Пүрэвсүрэн/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.БАЯСГАЛАН

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын
2020 оны 04 дүгээр сарын 24 өдрийн 55 дугаар
тушаалын хавсралт



СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ТЭНЦСЭН ЭМИЙН САНГИЙН ЖАГСААЛТ

№	Аж ахуйн нэгжийн нэр	Эмийн сангийн нэр	Байршил
1	"МЭИК" ХХК	"МЭИК-Чингэлтэй"	Чингэлтэй дүүрэг
2	"МЭИК" ХХК	"МЭИК-Төв"	Сүхбаатар дүүрэг
3	"Ази фарма" ХХК	"Ази фарм-Сүхбаатар"	Сүхбаатар дүүрэг
4	"Анхны нахиа" ХХК	"Анхны нахиа"	Сүхбаатар дүүрэг
5	"Гашуун булаг" ХХК	"Гашуун булаг"	Баянгол дүүрэг
6	"Гашуун булаг" ХХК	"Гашуун булаг фарм"	Баянзүрх дүүрэг